*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ТӨРИЙН САНГИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ МЯГМАР НЯМСҮРЭН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| <u>ЗОРИЛГО 5.</u> ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫГ ХАНГАЖ, ЭРХ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, САЛБАРЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЖ, САНХҮҮ, ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТӨЛӨВЛӨН ЗОХИЦУУЛЖ ИРГЭД ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЖ БАЙГАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДУНДАЖ ХУГАЦАА 2024 ОНД 47.5 ХОНОГ БАЙГААГ 2025 ОНД 30 ХОНОГТ ХҮРГЭНЭ. | | | | | | | |
| **НЭГ. Зорилт 1.** “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 5.1.1 “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| 1. | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Батлагдсан загвар маягтын дагуу, үнэн зөв, бодитой төлөвлөж, хугацаанд нь тайлагнах | | | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлагдсан загвар маягтын дагуу боловсруулж, хянуулан батлуулсан.<br>Төлөвлөгөөний дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж ажилласан. | 2025.01.01<br>2025.06.10 | 100 |
| 2. | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | Хуулийн хугацаанд багтааж шийдвэрлэсэн байх | | | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэж Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилласан. | 2025.01.01<br>2025.06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | Батлагдсан загвар маягтын дагуу үнэн зөв мэдүүлэх | | | Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасны дагуу 2022 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор гарган, Эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. | 2025.01.01<br>2025.02.15 | 100 |
| **<u>ГУРАВ.</u> Зорилт 1** <u>АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН</u> САЙДЫН БАГЦЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 2024 ОНД 95 ХУВЬ БАЙСНЫГ 2025 ОНД 2.0 ХУВИАР НЭМЭГДҮҮЛЖ, ТӨСВИЙН ИЛ ТОД, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ ДЭЭШЛҮҮЛНЭ. | | | | | | | |
| 5.3.1 "Салбарын сайд /төсвийн ерөнхийлөн захирагч/-ын 2025 оны батлагдсан төсөв, 2026 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарын санал, төсвийн төслийг боловсруулж батлуулах" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| 1. | Салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод үндэслэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөллийг боловсруулж хүргүүлэх, холбогдох тайлбар үндэслэлээр хангах; | Төсвийн тухай хуулийн 8.1.1, дүгээр зүйлийн биелэлт хангагдсан байх | | | Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон танилцуулгын дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэл болон экспортын төсөөлөл, бүтээгдэхүүний үнэ, 2025 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон экспортын хүлээгдэж буй гүйцэтгэл, 2026-2027 оны төсөөллийг холбогдох тайлбар, танилцуулгатайгаар Сангийн яаманд 2025 оны 04 дугаар сарын 16-ны өдрийн 01/1142 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 2025.02.01<br>2025.03.31 | 100 |
| 2. | Батлагдсан төсвийн хүрээг үндэслэн АҮЭБЯ-ийн сайд/ТЕЗ/-ын дараа жилийн төсвийн хязгаарын саналыг боловсруулж Санхүү,төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, холбогдох тайлбар, үндэслэлээр хангах; | Төсвийн тухай хуулийн 8.3.1, дүгээр зүйлийн биелэлт хангагдсан байх | | | 1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн саналыг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, | 2025.04.01<br>2025.06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эрэмблэх үйл ажиллагааны журам болон аргачлал"-ын дагуу боловсруулан Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлж, Сангийн яамны Хөрөнгө оруулалтын цахим системд 2025 оны шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний мэдээллийг хуулийн хугацаанд илгээж, холбогдож тайлбар үндэслэлээр ханган ажилласан.<br>2. Монгол Улсын Төсвийн тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсыг 2026-2031 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг баримтлан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2026 оны төсвийн хязгаарын санал, 2027-2028 оны төсөөллийг боловсруулан "2026 оны төсвийн хязгаарын санал, 2027-2028 оны төсөөлөл хүргүүлэх тухай" албан бичгийг Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 2026 оны 6 сарын 10 өдрийн 01/1795 джгаар албан бичгээр хүргүүлэн холбогдох тайлбар, үндэслэлээр ханган ажилласан. | | |
| 3. | АҮЭБС-ийн сайд/ТЕЗ/-ын дараа жилийн төсвийн төслийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, | АҮЭБ -ийн сайд/ТЕЗ/-ын дараа жилийн төсвийн төслийн саналыг | | | Хугацаа болоогүй | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, батлуулах; | боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн байх | | | | | |
| 4 | АҮЭБСайд/ТЕЗ/-ын Төсвийн тухай хуулиар батлагдсан хөтөлбөрийн хүрэх үзүүлэлтийн биелэлтийг нэгтгэн тайлагнах; | АҮЭБСайд/ТЕЗ/-ын Төсвийн тухай хуулиар батлагдсан хөтөлбөрийн хүрэх үзүүлэлтийн 2024 оны биелэлтийг нэгтгэн тайлагнасан байх | | | 1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд /Төсвийн ерөнхийлөн захирагч-ын “Уул уурхайн олборлолт” хөтөлбөрийн хүрэх үзүүлэлтийн 2024 оны биелэлтийг нэгтгэн боловсруулж Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн “Хөтөлбөрийн биелэлт хүргүүлэх тухай” 01/1593 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж биелэлтийг шилэн дансанд байршуулан ил тод байдлыг хангаж ажилласан. | 2025.01.01<br>2025.03.31 | 100 |
| 5.3.3 “Салбарын сайд /төсвийн ерөнхийлөн захирагч/ -ын төсвийн багцын зардлыг батлагдсан төвийн хүрээнд хуваарийн дагуу санхүүжүүлж гүйлгээг хянан баталгаажуулах, төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох газарт хүргүүлэх” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | АҮЭБ-ийн сайд /ТЕЗ/-ын батлагдсан төсвийн орлого, зарлагын хуваарийн саналыг боловсруулж, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, төсвийн программд нэгтгэх; | Хуваарийг үйл ажиллагаатай уялдуулан батлуулах | | | 2025 оны сар улирлын төсвийн хуваарийг Сангийн яамнаас батлахдаа зарим зардлуудыг 12 сард санхүүжүүлэхээр баталсан нь 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан зайлшгүй санхүүжүүлэх шаардлагатай зарим зардалд зохицуулалт хийж, хуваарьт өөрчлөлт оруулах нөхцөл байдлыг бий болгосон. АҮЭБСайдын багцын байгууллагуудын 2025 оны батлагдсан төсөвт холбогдох зохицуулалт хийлгэх, санхүүжилтийн хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлтийг | 2024.01.01<br>2024.06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эхний хагас жилийн байдлаар 4 удаа Сангийн яаманд хүргүүлж холбогдох өөрчлөлтийг оруулсан. | | |
| 2 | Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын багцын орлого төвлөрүүлэлт, хөрөнгө оруулалт, урсгал зардлын гүйцэтгэлд тулгамдсан асуудлыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж тайлбар үндэслэлийг танилцуулж, зохицуулалт хийлгэх; | Шаардлагатай төсвийн зохицуулалтыг Сангийн яаманд хүргүүлж холбогдох арга хэмжээг авсан байх | | | Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын багцын 2025 оны төсвийн зардлыг Монгол Улсын төсвийн тухай хуулиар 48.0 тэрбум төгрөгөөр баталсан. 2025 оны эхний хагас жилд үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарим зардлуудад зохицуулалт хийх шаардлага бий болсон тул АҮЭБЯ, Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологи алба, Цөмийн энергийн комиссын урсгал зардалд зохицуулалт хийлгэх хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлж холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын багцын урсгал зардалд 2025 оны эхний хагас жилийн байдлаар шаардлагатай зохицуулалтуудыг хийлгэсэн. | 2025.01.01<br>2025.06.10 | 100 |
| 3 | Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, цалин хангамжийг нэмэгдүүлэх, ажиллах боломжийг сайжруулах талаар батлагдсан төсөвт багтаан шаардлагатай арга хэмжээг тухай бүрт авч ажиллах | Шаардлагатай арга хэмжээг авч багтлагдсан төсөвт багтаан санхүүжүүлсэн байх | | | 1. АҮЭБЯ-ны албан хаагчдын 2025 оны урьдчилан сэргийлэх үзлэгийг хийлгэхээр ТТАХ-ийн эмнэлэгтэй байгуулсан гэрээний дагуу урьдчилан сэргийлэх үзлэгт 100 хувь хамруулаад байна. | 2025.01.01<br>2025.06.10 | 100 |
| 4 | АҮЭБЯ-ны төрийн сангийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах, төлбөр тооцоог төрийн сангийн төлбөр тооцооны журмын дагуу, эрхийн бүртгэлийн сан системийг ашиглан хөтөлбөр, төсөл, эдийн | Төрийн сангийн төлбөр тооцооны хэвийн үйл ажиллагаа хангагдсан байх | | | УУХҮС-ын харьяа байгууллагуудын төрийн сангийн өдөр тутмын гүйлгээний төлбөрийн хүсэлт нэг бүр нь төрийн сангийн төлбөр тооцооны журмын дагуу хийгдсэн эсэхэд нэг бүрчлэн хяналт тавьж, зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар, журмын дагуу хийгдсэн гүйлгээг хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн | 2025.01.01<br>2025.06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | засгийн ангилалын дагуу хянан баталгаажуулах; | хангагдсан байх | | | ангилал тус бүрээр хянан баталгаажуулж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны төрийн сангийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан. Төлбөр тооцоог төрийн сангаар гүйцэтгэхдээ 2025 оны батлагдсан зардлын хүрээнд Сангийн сайдын баталсан эдийн засгийн ангилал ашиглах заавар, журмын дагуу төлбөр тооцоог хийж байгаа эсэхэд сар бүр хяналт тавьж төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнүүдийг зөвлөмжөөр хангаж ажилласан. АҮЭБЯ яамны төрийн сангийн нэгжээр АҮЭБЯ, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба төлбөр тооцоогоо хийж байгаа бөгөөд эдгээр байгууллагуудын нийт 19 данс төрийн санд бүртгэлтэй байна. Мөн АҮЭБЯ-ны хөрвүүлэлтийн 100900018701 дансаар яам болон харъяа байгууллагуудын гадаад төлбөр тооцооны хөрвүүлэлтийг хийж сургалтын төлбөр болон гишүүнчлэлийн хураамжийн төлбөрийг шилжүүлж гадаад төлбөр тооцоог түргэн шуурхай хийж гүйцэтгээд байна.<br><br>Мөн АҮЭБС-ын багцын данснуудын орлого, зарлагын гүйлгээний баримтуудыг үндэслэн журнал бичилтүүдийг хийж гүйцэтгэсэн. | | |
| 5 | АҮЭБЯ -ны төрийн сангаар дамжуулан гадаад валютын төлбөр тооцооны журмын дагуу гадаад гүйлгээний программаар | Батлагдсан төсвийн орлого, зарлага, | | | Сангийн яамны Валютын төлбөр тооцооны нэгдсэн системээр дамжуулан Төрийн сангийн гадаад төлбөр тооцоог гадаад гүйлгээний программ ашиглан Төрийн банкаар дамжуулан гүйцэтгэлээ. | 2025.01.01<br>2025.06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлбөр тооцоог гүйцэтгэж хянан баталгаажуулах; | хөрөнгө оруулалтын хуваарийг харъяа байгууллагуудад хүргүүлсэн байх | | | Мөн Төрийн сангийн гадаад төлбөр тооцооны программаар дамжуулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хөрвүүлэлтийн 100900018701 дансаар Ашигт малтмал, газрын тосны газрын Улсын төсөвт төвлөрүүлэх газрын тосны хөрвүүлэлтийг сар бүр хийж, тухай бүр орлогыг төвлөрүүлсэн. | | |
| 6 | Төсөвт байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр харъяа байгууллагуудаас авч хянан баталгаажуулах, мэдээг нэгтгэн болосвруулж Сангийн яаманд хүргүүлэх; | Мэдээг нэгтгэн боловсруулж улирал бүр Сангийн яаманд хүргүүлсэн байх; | | | АҮЭБЯ, Ашигт малтмал, газрын тосны газар болон Үндэсний геологийн албаны санхүүгээс 2024 оны 12 сар, 2025 оны эхний 05 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг авч хянан баталгаажуулсан.<br>Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын багцын 2024 оны 12 сар, 2025 оны эхний 05 сарын гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн боловсруулж сар бүр хугацаанд нь Сангийн яамны төрийн сангийн газрын санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн М.Алтанхоролд хүргүүлж албажуулж ажилласан. | 2025.01.01<br>2025.06.10 | 100 |
| 5.3.6 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, яамны цахим хуудас болон засгийн газрын шилэн данс, цахим худалдан авах ажиллагааны системд хуулийн хугацаанд байршуулж, ил тод байдлыг ханган ажиллах.” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| 1 | 1 Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын багцын шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд байршуулах | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байх | | | АҮЭБСайдын багцын шилэн дансанд төсөвт төвлөрүүлж буй сар бүрийн орлогын мэдээ, төсвийн сар бүрийн зарлагын гүйцэтгэлийн мэдээ, батлагдсан төсөв болон төсөвт орсон өөрчлөлтийн мэдээ, хөтөлбөрийн биелэлтийн үзүүлэлтийг цаг тухай бүрт нь байршуулсан. 2025 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар нийт 17 мэдээ, мэдээллийг шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулж ил тод байдлыг ханган ажилласан байна. | 2025.01.01<br>2025.06.10 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Санхүү, төсөвтэй холбоотой шинээр мөрдөгдөж эхлэх хууль, дагалдах эрх зүйн баримт бичгүүдийг судлах, эрх зүйн мэдлэгээ нэмэгдүүлэх; | | | | Сангийн яамнаас жил бүр "Төсөв, санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал"- төслийн хүрээнд зохион байгуулсан яамдын санхүүгийн хэлтсийн дарга, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэл хариуцсан албан хаагчдад зориулсан сургалтад 2025 оны 06 дугаар сарын 6-наас 7-ны өдрүүдэд хамрагдаж сертификат авсан. | 2025.01.01<br>2025.06.10 | 100 |
| 2 | Мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс зохион байгуулагдах тасралтгүй боловсролын сургалтад хамрагдах | | | | Сургалт явагдаагүй. | 2025.01.01<br>2025.06.10 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Санхүүгийн хэлтсийн шинжээч ................................ / М.Нямсүрэн / 2025-06-18

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын*
*2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

**САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ШИНЖЭЭЧ**
**ОТГОНБАЯР ОВОГТОЙ ТУЯАЦЭЦЭГИЙН**
**2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| # | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах чиглэлээр нийгэм эдийн засгийн үндэслэлтэй судалгаа хийх, төлөвлөгөө боловсруулна. | Боловсруулсан төлөвлөгөө, судалгааны тоо | 0 | 1 | Эдийн засаг, хөгжлийн яам болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Азийн хөгжлийн банктай хамтран “Уур амьсгалын өөрчлөлт ба ухаалаг уул уурхай (TA 10237-MON)” төслийг хэрэгжүүлэхээр 2023.12.11-ний өдөр талууд санамж бичигт гарын үсэг зурж баталгаажуулсан. Дээрх төсөл нь Азийн хөгжлийн банкны 500,000 долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2024.01.01-2026.06.30-ны өдрийн хооронд Уул уурхай, хүнд үйлдвэр(хуучнаар)-ийн яаманд хэрэгжиж байна.<br>Төслийн хүрээнд АХБ-ны TA хүрээнд зохион байгуулагдах "Уул уурхайн хөрөнгө оруулагчдын форум"-ыг "Уул уурхайн долоо хоног"-ийн өмнө эсвэл дараа зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 2025.01.02<br>2025.06.10 | 100% |
| 2. | Арга хэмжээ 1.2. Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлнэ. | Эрх зүйн орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн байх | 0 | 1 | Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр ирүүлсэн Сангийн яам болон Эдийн засаг, хөгжлийн сайдаас ирүүлсэн Засгийн газрын тогтоолын төсөл болон хуулийн төсөлд холбогдох саналыг боловсруулан тухай бүр хүргүүлсэн. Дээрх чиглэлийн хүрээнд нийт 8 удаа Засгийн газрын тогтоолын төсөл, хуулийн төсөлд санал хүргүүлсэн байна. | 2025.01.02<br>2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Арга хэмжээ 1.3. Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээс Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэхтэй холбогдуулан төслийн нэгжүүдтэй хамтран ажиллана. | Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо | 2 | 2 | Монгол Улс-Герман Улсын хамтын ажиллагааны хүрээнд “Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ ТД 2020.2036.0” төсөл 2022 оны 4 дүгээр сараас эхлэн 2025.03.31-ний өдрийг дуустал амжилттай хэрэгжиж дууссан.<br>Төслийн хүрээнд Англи хэлний ярианы сургалтыг 2025 онд 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор яамны 62 албан хаагчдыг хамруулсан. Мөн ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан "Мэргэшсэн төслийн удирдагч (Project Management Professional)" бэлтгэх хүсэлтийн BGR-д хүргүүлсэн. Хүсэлтийн дагуу яамны 5 албан хаагчдыг 35 цагийн цахим болон танхимын сургалтад хамруулсан. Дээрх албан хаагчид Мэргэшсэн төслийн удирдагчийн шалгалт өгөх болзлыг хангаад байна.<br>-“Тогтвортой цэвэр эрчим хүчний сүлжээг хөгжүүлэх” Техникийн туслалцааны 10312 төслийг тус салбарт эхлүүлэхээр 2 талууд 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр тус яамны хурлын зааланд уулзалдаж санал солилцсон. Уулзалтын тэмдэглэлийн дагуу уг төсөлд тусгах нэмэлт саналыг боловсруулан 2 тал харилцан тохиролцож, 2025.06.10-ны өдөр баталгаажуулаад байна.<br>-Эдийн засаг, хөгжлийн яам болон Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Азийн хөгжлийн банктай хамтран “Уур амьсгалын өөрчлөлт ба ухаалаг уул уурхай (TA 10237-MON)” төслийг хэрэгжүүлэхээр 2023.12.11-ний өдөр талууд санамж бичигт гарын үсэг зурж баталгаажуулсан. Дээрх төсөл нь Азийн хөгжлийн банкны 500,000 долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2024.01.01-2026.06.30-ны өдрийн хооронд Уул уурхай, хүнд үйлдвэр(хуучнаар)-ийн яаманд хэрэгжиж байна. Зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх фирмийн тендерийн сонгон шалгаруулалтыг АХБ-аас зохион байгуулж, сонгон шалгаруулалтаар “Нова Терра” ХХК болон | 2025.01.02<br>2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Энержи маркетс групп" ХХК-иуд тус тус 2024.05.31-ний өдөр сонгогдсон. Төслийн нээлтийн уулзалтыг 2024.06.11-ний өдөр УУХҮЯ-ны хурлын зааланд, Төслийн талуудын уулзалтыг 2024.06.12-ны өдөр АХБ-ны хурлын зааланд зохион байгуулж төслийг эхлүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Төслийн зорилго: Монгол Улсад экспортод чиглэсэн нүүрстөрөгчийн хий багатай үйлдвэрүүд, тэр дундаа сэргээгдэх эрчим хүчний технологийн үйлдвэрлэлд шаардлагатай газрын ховор элементийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм. Тус төслийн зорилт нь нүүрстөрөгч бага ялгаруулдаг аж үйлдвэрийн стратеги, төлөвлөлтийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл, боломжуудыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг арилгахад шаардлагатай бодлогын багц шинэчлэлийг санал болгох, Засгийн газарт бодлогын баримт бичиг гаргахад дэмжлэг үзүүлэх, судалгааны баримт бичиг боловсруулах юм. Түүнчлэн цаг уурын өөрчлөлт, дэлхий нийтээр ногоон эдийн засагт шилжиж буй энэ үед шаардлагатай чухал ашигт малтмал болон бусад металлуудад төвлөрсөн аж үйлдвэрийг бий болгоход оролцогч талуудын дэмжлэгийг бий болгоход чиглэж байгаа болно.<br>Төслийн явц: Сонгон шалгаруулалтаар сонгогдсон төслийн баг нь Засгийн газрын байгууллагууд, салбарын мэргэжилтнүүд, орон нутгийн иргэд зэрэг гол оролцогч талуудтай хамтран ажиллах бөгөөд Монгол Улсын газрын ховор металлын салбарын хөгжлийг цогцоор нь судлах ажлыг зохион байгуулж байна. Энэ хүрээнд төслийн баг 2024.07.23-ны өдөр Эрдэнэс Монгол компанитай уулзалт зохион байгуулж, хамтын ажиллагааны боломжуудыг хэлэлцэж, төслийн зорилгуудыг үндэсний тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулах талаар ярилцсан. Судалгааны ажлын хүрээнд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдох тайлан, судалгааг цуглуулан, одоогийн нөхцөл байдал, шилдэг туршлагуудыг судалж байна. Энэхүү суурь судалгааны ажил нь төслийн дараагийн үе шатыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний технологийн үнэ цэнийн сүлжээний чухал ашигт малтмалын уур амьсгалын өөрчлөлтөд нийцсэн ухаалаг уул уурхайн байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын эрсдэлийг шийдвэрлэх АХБ-ны зөвлөлдөх семинарыг 2024.12.05-ны өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн 42 төлөөллүүд оролцсон.<br>Түүнчлэн Чухал ашигт малтмалын бодлогын семинарыг 2025.04.25-ны өдөр зохион байгуулж, хэлэлцүүлэгт хувийн хэвшлийн төлөөллүүд оролцож сэдвийн хүрээнд саналаа солилцсон. Хэлэлцүүлгээс Ашигт малтмалын тухай хуульд оруулах өөрчлөлтийн талаар санал гарч, саналыг тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан Ажлын хэсэгт хүргүүлэхээр тогтсон.<br>Төслийн хүрээнд АХБ-ны ТА хүрээнд зохион байгуулагдах "Уул уурхайн хөрөнгө оруулагчдын форум"-ыг "Уул уурхайн долоо хоног"-ийн өмнө эсвэл дараа зохион байгуулахаар санал солилцож байна. | | |
| 4. | Арга хэмжээ 1.4.<br>Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх эрдэм шинжилгээ, судалгааны ажлын саналыг нэгтгэн боловсруулна. | Саналыг нэгтгэн боловсруулсан байдал | 1 | 1 | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх эрдэм шинжилгээ, судалгааны ажлын саналыг харья байгууллага болон яамны дотоод нэгжүүдээс санал авч нэгтгэн Төсвийн төлөвлөлт, төрийн сан хариуцсан мэргэжилтэнд хүргүүлсэн. | 2025.01.02<br>2025.06.10 | 100% |
| **ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1.<br>Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн үйл | Гарсан санал, дүгнэлт оновчтой байх | Тухай бүр | Тухай бүр | “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” УИХ-ын 27 дугаар тогтоолоор батлагдсантай холбогдуулан хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсэгт орж ажилласан. | 2025.01.02<br>2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилт, үр дүнг тайлагнана. | | | | Монгол Улсын 2026-2030 оны Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг ТНБД-ын 2025.04.15-ны өдрийн А/64 тушаалаар байгуулж, Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажилласан. Ажлын хэсгийн хүрээнд яамны газар, нэгжүүд болон Эрдэнэс Монгол нэгдлийн төлөөлөлтэй хуралдаж, холбогдох саналыг загвар, маягтын дагуу боловсруулан ЭЗХЯаманд 2025.04.22-ны өдрийн 01/1215 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Тус яамнаас хүргүүлсэн хөгжлийн 14 төсөл, хөтөлбөрийн саналыг төсөл тус бүрээр ЭЗХЯ-ны http://invest.gov.mn/ цахим хуудсанд оруулж баталгаажуулсан. | | |
| 2 | Арга хэмжээ 2.2. Салбарын хууль тогтоомж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр боловсруулсан төсөлд санал зөвлөмж өгөх, хуульд нийцүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлнэ. | Боловсруулж, хүргүүлсэн байх | Тухай бүр | Тухай бүр | Хууль тогтоомж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр Засгийн газрын 12 тогтоол, шийдвэрт холбогдох саналыг боловсруулан хүргүүлсэн. | 2025.01.02 2025.06.10 | 100% |
| 3 | Арга хэмжээ 2.3. Салбарын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, тайлан, мэдээг нэгтгэн боловсруулах, хуулийн хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ. | Зохих хугацаанд нэгтгэн хүргүүлсэн байх | Тухай бүр | Тухай бүр | Монгол Улсын 2026-2030 оны Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг ТНБД-ын 2025.04.15-ны өдрийн А/64 тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд яамны газар, нэгжүүд болон Эрдэнэс Монгол нэгдлийн төлөөлөлтэй хуралдаж, холбогдох саналыг загвар, маягтын дагуу боловсруулан ЭЗХЯаманд 2025.04.22-ны өдрийн 01/1215 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Тус яамнаас хүргүүлсэн хөгжлийн 14 төсөл, хөтөлбөрийн саналыг төсөл тус бүрээр ЭЗХЯ-ны http://invest.gov.mn/ цахим хуудсанд оруулж баталгаажуулсан.<br>ЗГХЭГ-ын даргын 120 дугаар тушаалаар батлагдсан “Нээлттэй засгийн түншлэлийн 2024- | 2025.01.02 2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2027 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг гарган ТЗУГ-т хүргүүлсэн. "Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" УИХ-аар батлагдсантай холбогдуулан. Хөтөлбөрийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан. | | |
| 4 | Арга хэмжээ 2.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайланг хуулийн хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ. | Зохих хугацаанд нэгтгэн хүргүүлсэн байх | 12 | 6 | Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хамаарах "Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт"-ийн тайланг гарган сар бүр ТЗУГ-т хүргүүлсэн. | 2025.01.02 2025.06.10 | 100% |
| 5 | Арга хэмжээ 2.5. Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ. | Зохих хугацаанд нэгтгэн хүргүүлсэн байх | 1 | 1 | Гадаадын тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний жагсаалт, хэрэгжилтийн талаарх мэдээллийг odamis.mof.gov.mn цахим системийн төсөл арга хэмжээ хуудасны холбогдох хэсэгт тухай бүр мэдээллийг оруулж, файлын сан үүсгэсэн.<br>Тус системд бүртгэлтэй зээлийн 1, буцалтгүй тусламжийн 5 төсөл Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Цөмийн энергийн комиссын Ажлын алба болон Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ-т хэрэгжиж байна.<br>Хууль тогтоомжийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4-д заасан шаардлагын дагуу гадаад болон монгол хэл дээр хийсэн гэрээг ODAMIS системд бүртгэлтэй төсөл, арга хэмжээ тус бүрийн файлын сан хэсэгт байршуулж ажилласан.<br>Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг АМГТГ, ҮГА, ГСШТ болон ЦЭК-ын Ажлын албанаас авч нэгтгэн боловсруулж ХШҮДАГ-т 2025.02.25-ны өдөр хүргүүлсэн. | 2025.01.02 2025.03.31 | 100% |
| **ГУРАВ. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1. | Төлөвлөгөөг боловсруулж | 1 | 1 удаа | Төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан | 2025.01.02 2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах. | тайлагнасан байна | | | батлуулж, 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг ТЗУГ хүргүүлсэн. | | |
| 2. | Арга хэмжээ 3.2.<br>Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлүүлэх, хариу хүргүүлэх арга хэмжээ авч, хэрэгжилтийг нэгтгэн холбогдох газарт хүргүүлнэ. | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх. | Тухай бүр | Тухай бүр | Салбарын үйл ажиллагаатай холбоотой иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, тухай бүр холбогдох хариуг хүргүүлсэн.<br>2025.01.02-06.10-ны өдрийн байдлаар нийт 35 албан бичигт хариу санал боловсруулсан албан бичиг болон цахим шуудангаар хүргүүлсэн байна. Эхний хагас жилийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлт, өргөдөл, болон гомдол ирээгүй байна. | 2025.01.02<br>2025.06.10 | 100% |
| 3. | Арга хэмжээ 3.3.<br>АҮЭБЯ-ны сайд болон ТНБД-ын шуурхай хуралдаанаас өгсөн чиг үүргийн дагуу холбогдох үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж, тайлагнана. | Хэрэгжилт хангагдсан байх | Тухай бүр | Тухай бүр | АҮЭБЯ-ны сайд болон ТНБД-ын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврыг тухай бүр биелүүлж ажилласан. | 2025.01.02<br>2025.06.10 | 100% |

## ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| # | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Гадаад хэлний мэдлэг, мэдээллийн технологийн болон мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдана. | Сургалтад хамрагдсан байна. | - | 100% | “Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ” төслийн хүрээнд яамны албан хаагчдын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх сургалтад хамрагдаж, ярианы англи хэлний 8 болон 9 дугаар шатлалыг тус тус амжилтай төгсөж, гэрчилгээ авсан. | 2025.01.02<br>2025.02.25 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ХБНГУ-ын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн (BGR)-тэй хамтран хэрэгжүүлсэн “Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ” (ТД 2020.2036.0) төслийн хүрээнд зохион байгуулсан "Мэргэшсэн төслийн удирдагч (Project Management Professional)" 35 цагийн цахим сургалтад хамрагдсан. | 2025.01.02<br>2025.03.31 | 100% |
| 2. | Хариуцсан ажил, албан тушаалын зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалт, хурал, зөвлөгөөнд оролцоно. | Сургалтад хамрагдсан байна. | - | 100% | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилт, гүйцэтгэл, хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлууд сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон. | 2025.03.23 | 100% |
| | | | | | Засгийн газрын гадаадын зээл, тусламжийн удирдлага, зохицуулалтын чиглэлээр яамд, төсөл хэрэгжүүлэгч байгууллагын чадавх бэхжүүлэх уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон. | 2025.05.20 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Шинжээч ................................ /О.Туяацэцэг/ 2025.06.10

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.БАТЖАРГАЛЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. "Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах"** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Боловсруулсан мэдээллийн гүйцэтгэлийн хувь | 0 | 40% | -Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлагдсан загвар маягтын дагуу боловсруулж, хянуулан, батлуулахад бэлэн болгож, ТЗУГ-ын асуудал хариуцсан мэргэжилтэнд 2025 оны 1 дүгээр улиралд багтаан хүлээлгэн өгсөн.<br>- Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилттэй холбоо тойгоор өмнөх онуудад болон 2025 онд гарсан УИХ, ЗГ-ын тогтоол, шийдвэрүүдээс хамаарал бүхий асуудлуудын хэрэгжилтийг гарган 2025 оны 1 дүгээр улирлаар ТЗУГ-ын асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Санчирт нэгтгүүлэн тайлагнасан. | 2025.01.01-2025.06.10 | 100% |
| 2. | Арга хэмжээ 1.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | Нийт ирсэн өргөдөл, гомдолд шийдвэрлэж хариу өгсөн хувь хэмжээ | 0 | 50% | Тайлант хугацаанд удирдлагаас цохогдож ирсэн 50, дотоод бичгээр ирсэн 1 албан бичгийг шийдвэрлэн, хуулийн хугацаанд нь хариуг өгч ажилласан. Хариутай болон хугацаатай албан бичгүүдийг шийдвэрлэлтэд анхаарч, нийт 32 албан бичгийг гадагш илгээсэн. Хугацаа хэтэрсэн болон шийдвэрлэгдээгүй албан бичиг байхгүй. | 2025.01.01-2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Арга хэмжээ 1.3. Өмнөх онд зохион байгуулагдсан тендер шалгаруулалттай холбоотой баримт материалуудын бүрдлийг хангуулан, архивын нэгж үүсгэх, архивт хүлээлгэн өгөх | Архивын нэгжийн тоо | 0 | 5 | Өмнөх онд зохион байгуулагдсан тендер шалгаруулалттай холбоотой нийт 6 боть бүхий 968 хуудас материалыг цэгцэлж, дугаарлан архивын нэгж үүсгэн хүлээлгэн өгсөн. | 2025.01.01-2025.03.10 | 100% |
| 4. | Арга хэмжээ 1.4. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | ХАСХОМ | 0 | 1 | Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасны дагуу 2025 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор гарган, Эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. | 2025.01.01-2025.02.15 | 100% |
| **Зорилт 2. “Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн ил тод байдлыг хангаж ажиллах”:** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. Захиалагч /ТЕЗ/-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, АҮЭБ-ийн сайдын харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хянах, сайдын тушаалаар батлуулах | Батлагдсан төлөвлөгөөний тоо | 0 | 4 | - Захиалагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний төслийг боловсруулан, АҮЭБ-ийн сайдын 2024.12.31-ний өдрийн А/106, А/107, А/108 дугаар тушаалуудаар батлуулсан.<br>- Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025.02.06-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөөг баталсантай холбогдуулан АҮЭБ-ийн сайдын 2025.02.27-ны өдрийн А/43 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлуулсан.<br>- Мөн АҮЭБ-ийн сайдын 2025.04.22-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар дээрх худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд нэмэлт оруулан батлуулсан.<br>- “Эрчис ойл” компанийн худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг хянан, цахимаар хянан батлах ажлыг хийж гүйцэтгэсэн. | 2025.01.01-2025.04.22 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Арга хэмжээ 2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулахад хамтран ажиллах | Батлагдсан төсөл арга хэмжээний тоо | 0 | 1 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан 3 багц бүхий 984.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг АҮЭБ-ийн сайдын 2025.01.09-ний 01/36 тоот албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн.<br>Төрийн худалдан авах ажиллагааны газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу 3 багцад нийт 779.5 сая төгрөгийн гэрээг шалгарсан оролцогчидтой байгуулсан.<br>- Багц 1-д “Саммит компьютер технологи” ХХК<br>- Багц-2-т “Арвис системс” ХХК<br>- Багц-3-т “Хөтөл нутаг” ХХК .<br>Холбогдох мэдээллийг Улсын төсвийн хөрөнгө оруулалтын www.pimis.publicinvestment.gov.mn цахим системд оруулсан. | 2025.01.09-2025.06.10 | 100% |
| 3. | Арга хэмжээ 2.3. Захиалагч /ТЕЗ/-ийн болон АҮЭБ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулах, баталгаажуулах | Цахим системд баталгаажуулсан төлөвлөгөөний тоо | 0 | 4 | АҮЭБ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа АҮЭБЯ, АМГТГ, ҮГА, ЦЭКАА болон “Эрчис ойл” зэрэг байгууллагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлагдсан сайдын тушаал, холбогдох баримт бичгүүдийг үндэслэн Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулан, баталгаажуулах ажлыг гүйцэтгэсэн. Тайлант хугацаанд нийт 12 удаагийн өөрчлөлтийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. | 2025.01.09-2025.06.10 | 100% |
| 4. | Арга хэмжээ 2.4. Бараа таваарыг нийлүүлэх, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Тендерийн үнэлгээний хороодыг байгуулах, хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах | Тендер шалгаруулалтын тоо | 0 | 4 | Захиалагчид шаардлагатай худалдан авах ажиллагааг зохион байгуулахтай холбоотойгоор 2025 онд нийт 8 үнэлгээний хороог АҮЭБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулсан. (А/28, А/65, А/66 дугаар тушаалаар тус тус)<br>Худалдан авах ажиллагаа 2025 оны эхний хагас жилийн байдлаар:<br>1. ОҮИТБС-ын 2024 оны нэгтгэл тайлан боловсруулах ажлын тендер шалгаруулалтыг | 2025.01.01-2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулж, шалгарсан “SICA” ХХК-тай 2025.04.28-ны өдөр 23 дугаартай гэрээ байгуулсан. Гэрээний үнийн дүн 109.0 сая ₮,<br>2. Байрны түрээсийн тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан “Раашбулаг” ХХК-тай 2025.05.19-ны өдөр 29 дугаартай гэрээ байгуулсан. Гэрээний үнийн дүн 96.0 сая ₮,<br>3. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлан, шалгарсан оролцогч “Андхайрхан” ХХК-д 2025.05.29-ний өдөр 134.9 сая төгрөгөөр гэрээ байгуулах эрх олгоод байна.<br>4. Багаж, техник, хэрэгсэл тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан “Монтех дистрибьюшн” ХХК-тай 2025.05.28-ны өдөр 35 дугаартай гэрээ байгуулсан. Гэрээний үнийн дүн 99.9 сая ₮,<br>5. Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний 3 багц бүхий тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан оролцогчидтой 2025.05.28-ны өдөр 32, 33, 34 дугаартай гэрээг тус тус байгуулсан.<br>6. Ерөнхий гэрээний аргаар цахим дэлгүүрээс Компьютер худалдан авах тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан “Саммит Компьютер Технологи” ХХК-тай 2025.05.19-ний өдрийн АҮЭБЯ/010/001/36 дугаартай гэрээг байгуулсан. Гэрээний үнийн дүн 13.9 сая ₮. | | |
| 5. | Арга хэмжээ 2.5. Албан хаагчдын ТБОНӨХБАҮХАТ хуулийг хэрэгжүүлэх мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор А3 сертификат олгох сургалт зохион байгуулах | Зохион байгуулах сургалтын тоо | 0 | 1 | Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А3 сертификат олгох сургалтад хамруулах албан хаагчдын нэрсийг газар, хэлтсүүдээс дотоод бичгээр санал авч 2025 оны 2 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулсан. Нийт 30 албан хаагчийг хамруулсан. Сертификат авсан 7. | 2025.01.01-2025.02.25 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | Арга хэмжээ 2.6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын баталсан журмын дагуу худалдан авах ажиллагааг хугацаанд нь тайлагнаж, ил тод байдлыг хангах | Илгээсэн тайлангийн тоо | 0 | 2 | - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу АҮЭБ-ийн сайдын болон харьяа байгууллагуудын 2024 оны худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланг нэгтгэн боловсруулж, Сангийн яаманд 2025.01.15-ны өдрийн 01/110 тоот албан бичгээр хүргүүлэн тайлагнасан.<br>- Тус тайлангийн хавсралтаар АҮЭБ-ийн сайдын 2024 онд Ерөнхий гэрээний журмаар худалдан авсан бараа, үйлчилгээний тайланг батлагдсан маягтын дагуу гаргаж хүргүүлсэн. | 2025.01.01-2025.01.15 | 100% |
| **Зорилт 3. “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, Яамны цахим хуудас болон Засгийн газрын Шилэн данс, Цахим худалдан авах ажиллагааны системд хуулийн хугацаанд байршуулж, ил тод байдлыг ханган ажиллах”:** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 3.1. Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, бусад журмын хэрэгжилтийг хангах, тайлагнах, мэдээ мэдээллийг нэгтгэх | Ил тод байршуулах мэдээллийн тоо | 0 | 8 | - АҮЭБ-ийн яамны болон сайдын багцын 2024 оны худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн боловсруулж, 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Шилэн дансанд нийтэлсэн.<br>- Худалдан авах ажиллагаатай холбоотой тайлан мэдээг сар бүр, аудит болон хяналт шалгалтын дүгнэлтийг тухай бүр “Шилэн данс”-ны цахим хуудсанд оруулж ажилласан. Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны тайланг 6 удаа, хяналт-шалгалт, аудитын дүгнэлтийг 2 удаа оруулсан байна. | 2025.01.01-2025.06.10 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Монгол бичгээр албан хэрэг хөтлөх ур чадвараа нэмэгдүүлэх | Судалсан цаг | 0 | 20 | - Бие даан Монгол бичгээр албан хэрэг хөтлөх ур чадвараа нэмэгдүүлж байна. | 2025.01.01-2025.06.10 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах мэргэжилтэн — Б.Батжаргал / ........................ / — 2025- 06- 10

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*